**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/78/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт ....... 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 12
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....... 12
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....... 12
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 13
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ....... 13
4. Аудитын тайлан ....... 16
    4.1 Ерөнхий зүйл ....... 16
    4.2 Материаллаг байдал ....... 16
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ....... 16
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 16
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 17
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 17
5. Аудитын илрүүлэлт ....... 17


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

УВС АЙМГИЙН ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.БАТТУЛГА ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400. Увс аймаг. Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.06 № УВА-2023/78/НА-СТА-7443
танай____________-ны №______________-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1.2-т заасанаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн баталсан байна.

Мөн Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоол, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2018 оны 83 дугаар тогтоолыг үндэслэн аймаг нийслэл дэх Шүүхийн тамгын газрын дэргэд “Ахмадын сан” байгуулж 2022 онд 7,000.0 мянган төгрөгийг 12 сард олгож тайланд онд зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,289,214.00** | **33,811,189.00** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 7,000,000.00 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 7,000,000.00 |
| 3121 | **Төгрөг** | 00.00 | 7,000,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 7,000,000.00 |
| 33 | **АВЛАГА** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 335 | **Бусад авлага** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 24,289,214.00 | 24,811,189.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 24,289,214.00 | 24,811,189.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,446,900.00 | 8,431,160.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,572,414.00 | 16,230,129.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 269,900.00 | 149,900.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **766,813,300.10** | **786,841,720.47** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 766,813,300.10 | 786,841,720.47 |
| 392 | **Биет хөрөнгө** | 723,997,302.05 | 743,553,847.38 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 628,309,270.00 | 628,309,270.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -46,801,984.45 | -62,973,635.41 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 171,350,000.00 | 99,350,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -111,933,333.35 | -31,133,333.37 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 204,491,536.01 | 121,293,897.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -137,708,658.86 | -49,117,201.09 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 103,629,327.40 | 81,469,962.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -89,372,149.70 | -45,748,407.54 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -530,000.00 | -650,000.00 |
| 39217 | Ном | 1,363,295.00 | 1,553,295.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 42,815,998.05 | 43,287,873.09 |
| 39301 | Програм хангамж | 1,825,000.00 | 1,825,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,137,499.95 | -665,624.91 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 42,128,498.00 | 42,128,498.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **793,102,514.10** | **820,652,909.47** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **793,102,514.10** | **820,652,909.47** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 793,102,514.10 | 820,652,909.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 610,411,472.11 | 610,411,472.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 610,411,472.11 | 610,411,472.11 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 7,915,582.60 | 35,465,977.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,915,582.60 | 7,915,582.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 27,550,395.37 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 174,775,459.39 | 174,775,459.39 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **793,102,514.10** | **820,652,909.47** |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,286,558,647.00** | **1,439,432,630.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **128,601,947.00** | **77,014,230.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 93,234,247.00 | 77,014,230.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 61,675,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/ | 92,824,759.00 | 12,705,940.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/ | 409,488.00 | 2,633,290.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 35,367,700.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 35,367,700.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,157,956,700.00** | **1,362,418,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,151,496,700.00 | 1,362,418,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,151,496,700.00 | 1,362,418,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,460,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,460,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,199,300,668.69** | **1,411,882,234.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,199,300,668.69** | **1,411,882,234.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,130,487,553.25 | 1,326,135,904.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 769,482,180.00 | 979,125,992.00 |
| 210101 | Үндсэн цалин | 602,173,093.00 | 674,874,574.00 |
| 210102 | Нэмэгдэл | 115,271,963.00 | 233,239,098.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,938,000.00 | 31,420,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,099,124.00 | 39,592,320.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 100,274,907.56 | 122,090,690.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,304,173.51 | 83,757,795.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,801,919.23 | 9,853,858.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,179,470.52 | 7,862,000.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,453,540.58 | 1,893,444.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,535,803.72 | 18,723,591.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,121,734.00 | 49,302,027.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,903,865.00 | 5,525,163.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,719,625.00 | 40,719,625.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,226,244.00 | 1,817,239.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,272,000.00 | 1,240,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,604,523.00 | 69,620,213.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 18,520,788.00 | 25,610,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,019,600.00 | 20,500,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,706,735.00 | 9,999,933.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,508,300.00 | 840,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,853,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,996,100.00 | 12,548,970.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 237,810.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 237,810.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 108,198,643.00 | 29,057,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 108,198,643.00 | 29,057,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,366,000.00 | 5,948,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,366,000.00 | 5,948,000.00 |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,692,585.00 | 11,400,802.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,639,250.00 | 7,734,945.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,039,125.00 | 2,369,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 133,710.00 | 133,932.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,696,500.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 398,000.00 | 398,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,946,980.69 | 59,352,519.63 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,946,980.69 | 59,352,519.63 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 68,813,115.44 | 85,746,330.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,588,560.00 | 1,940,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,588,560.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,940,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 31,224,555.44 | 83,806,330.40 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,224,555.44 | 83,806,330.40 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **87,257,978.31** | **27,550,395.37** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 400,044.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 400,044.00 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -400,044.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **86,857,934.31** | **27,550,395.37** |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,158,089,700.00** | **1,369,418,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **7,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 7,000,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 7,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,158,089,700.00** | **1,362,418,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,151,496,700.00 | 1,362,418,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,151,496,700.00 | 1,362,418,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,593,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,593,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,140,090,900.00** | **1,357,418,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,140,090,900.00** | **1,357,418,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,071,277,784.56** | **1,271,672,069.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 769,482,180.00 | 979,125,992.00 |
| 210101 | Үндсэн цалин | 602,173,093.00 | 674,983,934.00 |
| 210102 | Нэмэгдэл | 115,271,963.00 | 233,239,098.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,938,000.00 | 31,420,000.00 |
| 210104 | Урамшуулал | 29,099,124.00 | 39,482,960.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 100,274,907.56 | 122,090,690.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,304,173.51 | 83,757,795.40 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,801,919.23 | 9,853,858.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,179,470.52 | 7,862,000.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,453,540.58 | 1,893,444.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,535,803.72 | 18,723,591.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,121,734.00 | 49,302,027.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,903,865.00 | 5,525,163.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,719,625.00 | 40,719,625.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,226,244.00 | 1,817,239.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,272,000.00 | 1,240,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 51,980,435.00 | 67,673,708.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,933,700.00 | 23,100,760.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,019,600.00 | 20,525,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,706,735.00 | 10,419,933.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,508,300.00 | 420,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,853,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,959,100.00 | 13,087,405.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 800,000.00 | 198,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 198,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 88,559,943.00 | 28,932,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 88,559,943.00 | 28,932,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,366,000.00 | 5,948,000.00 |



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 6,366,000.00 | 5,948,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,692,585.00 | 11,400,802.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,639,250.00 | 7,734,945.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,039,125.00 | 2,369,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 133,710.00 | 133,932.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,696,500.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 398,000.00 | 398,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 7,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 7,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **68,813,115.44** | **85,746,330.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,588,560.00 | 1,940,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,588,560.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,940,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 31,224,555.44 | 83,806,330.40 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,224,555.44 | 83,806,330.40 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **17,998,800.00** | **12,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **17,998,800.00** | **5,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **17,998,800.00** | **5,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 17,998,800.00 | 5,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 17,998,800.00 | 5,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-17,998,800.00** | **-5,000,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 7,000,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 7,000,000.00 |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 610,411,472.11 | 175,118,303.39 | -79,285,195.71 | 00.00 | 706,244,579.79 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 342,844.00 | 00.00 | 342,844.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **610,411,472.11** | **175,118,303.39** | **-78,942,351.71** | **00.00** | 706,587,423.79 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | -342,844.00 | 00.00 | 00.00 | -342,844.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 86,857,934.31 | 00.00 | 86,857,934.31 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **7,915,582.60** | **00.00** | 793,102,514.10 |
| D01 | **2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **7,915,582.60** | **00.00** | 793,102,514.10 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **7,915,582.60** | **00.00** | 793,102,514.10 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 27,550,395.37 | 00.00 | 27,550,395.37 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **35,465,977.97** | **00.00** | 820,652,909.47 |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,362,418,400.00 | 1,278,612,069.60 | 83,806,330.40 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,362,418,400.00 | 1,278,612,069.60 | 83,806,330.40 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,360,418,400.00 | 1,276,672,069.60 | 83,746,330.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,052,426,100.00 | 979,125,992.00 | 73,300,108.00 |
| 210101 | Үндсэн цалин | 695,133,300.00 | 674,983,934.00 | 20,149,366.00 |
| 210102 | Нэмэгдэл | 306,855,300.00 | 233,239,098.00 | 73,616,202.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,974,000.00 | 31,420,000.00 | (5,446,000.00) |
| 210104 | Урамшуулал | 24,463,500.00 | 39,482,960.00 | (15,019,460.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 131,553,300.00 | 122,090,690.60 | 9,462,609.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 89,456,200.00 | 83,757,795.40 | 5,698,404.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,524,300.00 | 9,853,858.20 | 670,441.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,419,400.00 | 7,862,000.86 | 557,399.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,104,900.00 | 1,893,444.80 | 211,455.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,048,500.00 | 18,723,591.34 | 2,324,908.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,322,000.00 | 49,302,027.00 | 19,973.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,300,000.00 | 5,525,163.00 | (225,163.00) |
| 210302 | Түлш, халаалт | 40,750,000.00 | 40,719,625.00 | 30,375.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 1,817,239.00 | 182,761.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,272,000.00 | 1,240,000.00 | 32,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 67,674,000.00 | 67,673,708.00 | 292.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 23,011,000.00 | 23,100,760.00 | (89,760.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,659,300.00 | 20,525,610.00 | (866,310.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,543,700.00 | 10,419,933.00 | 2,123,767.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 420,000.00 | 580,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | 120,000.00 | 540,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,800,000.00 | 13,087,405.00 | (2,287,405.00) |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | 198,000.00 | 2,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 198,000.00 | 2,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33,933,400.00 | 33,932,850.00 | 550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 5,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 28,933,400.00 | 28,932,850.00 | 550.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,547,800.00 | 5,948,000.00 | 599,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,547,800.00 | 5,948,000.00 | 599,800.00 |



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,761,800.00 | 11,400,802.00 | 360,998.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,050,000.00 | 7,734,945.00 | 315,055.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,387,200.00 | 2,369,925.00 | 17,275.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,600.00 | 133,932.00 | 6,668.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 44,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 398,000.00 | 398,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,000,000.00 | 7,000,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,000,000.00 | 7,000,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,000,000.00 | 1,940,000.00 | 60,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 1,940,000.00 | 60,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,940,000.00 | 60,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,362,418,400.00 | 1,278,612,069.60 | 83,806,330.40 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,362,418,400.00 | 1,278,612,069.60 | 83,806,330.40 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,362,418,400.00 | 1,278,612,069.60 | 83,806,330.40 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 05.00 | 05.00 | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 05.00 | 05.00 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37.00 | 35.00 | 2.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 05.00 | 05.55 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28.00 | 26.00 | 2.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- ✓ Төсвийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд, Нийгмийн даатгал болон татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаарын сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- ✓ Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,550.4 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 7,000.0 | 7,000.0 |
| Авлага | 2,000.0 | 2,000,0 | 0.00 |
| Бараа материал | 24,289.2 | 24,811.2 | 522.0 |
| Үндсэн хөрөнгө | 766,813.3 | 786,841.7 | 20,028.4 |
| **Нийт хөрөнгө** | **793,102.5** | **820,652.9** | **27,550.4** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 793,102.5 | 820,652.9 | 27,550.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **793,102.5** | **820,652.9** | **27,550.4** |

Мөнгөн хөрөнгө 2022 онд 7,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Тухайн тайлан хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол, Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын дагуу бүх Шүүхийн тамгын газруудад шинээр ахмадын сангийн данс нээж Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс салбар ахмадын хороо бүрт төсвийн ерөнхийлөн захирагчаас мөнгөн хөрөнгө олгосон байна. Увс аймаг дахь Шүүхийн тамгын газарт 12 дугаар сард 7,000.0 мянган төгрөгийг олгож тайлант онд зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнасан байна.

Авлага дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг нь 2018 оны жилийн эцэст иргэнээс авах шүүхийн шийдвэр гарсан бөгөөд одоогоор гүйцэтгэх хуудсаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа тул авлага дансанд үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24,811.2 мянган төгрөг болж 522.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 786,6841.7 мянган төгрөг болж 20,028.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 4,850.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр бэлтгэн, балансаас балансад 12,705.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлж авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,455,100.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 92,681.6 мянган төгрөгөөр бууруулж 1,206,561.1 мянган төгрөгөөр баталсан байна. 2022 оны төсвийн төслийг 248,538.9 мянган төгрөгөөр бууруулан баталсан нь шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын цалинг оны эхнээс 2

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

дахин нэмэгдүүлнэ гэж УИХ-ын тогтоол гарсан боловч 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс олгосон, мөн иргэний хэргийн шүүхийн 1 шүүгчийн орон тоог зарлаж томилоогүй тул цалингийн санг бууруулсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор 155,857.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,362,418.4 мянган төгрөгөөр баталсан байна.
Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,278,612.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.
Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,178,612.1 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 83,806.3 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70701,80101 | 1,359,718.4 | 1,276,258.3 | 83,460.1 | 93.8 |
| 2 | 70701,80224 | 500.0 | 363.75 | 136.25 | 72.7 |
| 3 | 70701,80802 | 2000.0 | 1940.0 | 60.0 | 97.0 |
| 4 | 70701,82321 | 200.0 | 50.0 | 150.0 | 25.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,996.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,411,882.2 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 7,059.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,647.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСҮРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 06-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ